Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,475,591.4 мянган төгрөг болж 348,559.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 54,792.5 мянга, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13,950.0 мянган төгрөгийн мотоцикл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 295,687.0 мянган төгрөгийн хөрөнгө тус тус шилжүүлэн авсантай холбоотой байна.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор тус сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 9,809.8 мянган төгрөгийн өртөгтэй 2 ширхэг, нийт 19,619.7 мянган төгрөгийн мотор дутагдсан тул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/382 тоот албан бичгийг үндэслэн данснаас хасаж авлагаар бүртгэсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 121.0 мянган төгрөг болж өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,677,269.4 мянган төгрөг болж 305,976.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 305,976.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 840,824.6 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 600.0 мянга, нийт зарлагыг 841424.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 251,011.9 мянган төгрөгөөр бууруулж 1,045,676.5 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 1,319,322.7 мянган төгрөг болгож 273,646.2 мянган төгрөгөөр өсгөн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 815,980.4 мянган төгрөг батлагдсанаас 698,049.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 698,049.6 мянган төгрөг буюу 86 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 116,930.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80801 үндсэн үйл ажиллагаа зардал | 506,202.5 | 479,955.3 | 26,247.2 | 95% |
| 2 | 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал | 134,493.5 | 131,476.7 | 3,016.8 | 98% |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 5,000.0 | 4,993.0 | 7.0 | 100% |
| 4 | 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 52,865.3 | 33,015.0 | 19,850.3 | 62% |
| 5 | 81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал | 112,019.1 | 44,277.5 | 67,741.6 | 40% |
| 6 | 82212 Хүр хог хаягдал, орчны бохирдол | 4,400.0 | 4,332.1 | 67.9 | 98% |
| | Нийт дүн | 814,980.4 | 698,049.6 | 116,930.8 | 86% |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 26,247.2 мянга буюу 5 хувь, баг хорооны үйл ажиллагааны зардлаас 3,016.8 мянга буюу 2 хувь, орон нутгийн нөөц хөрөнгө хөрөнгө 19,850.3 мянга буюу 38 хувь, байгаль орчны хамгаалах нөхөн сэргээх зардал 67,741.6 буюу 60 хувь, хур хаягдал, орчны бохирдлын зардлаас 67.9 мянга 2 хувийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дараах орлого төвлөрсөн байна.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* */мян.төг/*

| д/д | Орлогын төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | Мал тооллоыгн зардал/Статистикийн хэлтэс/ | 1,390.8 |
| 2 | Халдваргүйтлийн мөнгө | 390.0 |
| 3 | Аймгийн ЗДТГ /Сургалтын шатахуун/ | 428.1 |
| | Нийт орлогын дүн | 2,208.9 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Дээрх орлогыг зориулалтын дагуу зарцуулж 100.2 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баацагаан сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, ахлах аудитор М.Алтантуяа, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баацагаан сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 2/05 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2023 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Б.Наранбаатар, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Анхтуяа нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 588,423.3 мянган төгрөгөөс тооцоход 8,826.3 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 6,178.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны гэрэл цахилгааны зардлыг 387.2 мянга буюу 7.8 хувь хэмнэсэн байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 152 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 805,910.4 мянган төгрөгийн 16 гүйлгээ мэдээлэхээс 48,135.1 мянган төгрөгийн 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 203,822.0 мянган төгрөгийн 10 гүйлгээ мэдээлэхээс 87,591.9 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 109,742.6 мянган төгрөгийн 41 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг хугацаанд үнэн зөв мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 31,536.8 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 19,619.7 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 11,917.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн ба Баацагаан сумын ЗДТГ-ын 2023.06.06-ны өдрийн 2/76 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | **1** | **19,619.7** | **1** | **19,619.7** | **100** |
| Зөвлөмж | 2 | 11,917.1 | 2 | 11,917.1 | 100 |
| **Нийт дүн** | **3** | **31,536.8** | **3** | 31,536.8 | 100 |

Эх сурвалж: 2023 оны аудитын тайлангаас

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,400.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөөс дансны хуулгаар 33,015.5 мянган төгрөгийг зарцуулсан байхад 33,315,500 төгрөгөөр, байгаль нөхөн сэргээх арга хэмжээний 44,277.5 төгрөг зарцуулсан байхад 40,227.5 төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 174,962.3 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 162.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 31,673.3 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 135,727.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлэв.

**5.1 Төлбөрийн акт**

1. Тамгын газрын дарга Б.Наранбаатар нь албан томилолтоор 2023 оны 01 сарын 18-аас 4 хоног Галуут сумд ажилласан бөгөөд нягтлан бодогч албан томилолтын нөхөн олговрыг олгохдоо аймгийн төвд ажилласнаар тооцож 162.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Сангийн сайдын 2022.06.02-ны өдрийн 120 дугаар тушаалын 1 дэх заалтын зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Илүү олгосон томилолтын 162.0 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

1. Тайлант онд урсгал засварын зардал болон хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас авто тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгсэл авахад 31,673.0 мянган төгрөг зарцуулсан байхад тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т " Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийг солихдоо батлагдсан норм стандартын дагуу тухай бүр дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Тус байгууллага нь 2023 онд 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 152 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 805,910.4 мянган төгрөгийн 16 гүйлгээ мэдээлэхээс 48,135.1 мянган төгрөгийн 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 203,822.0 мянган төгрөгийн 10 гүйлгээ мэдээлэхээс 87,591.9 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 109,742.6 мянган төгрөгийн 41 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга,

хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх актын төлбөрийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----------оОо-----------

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн | 1 | 7,400.0 | - | - | 1 | 7,400.0 | 1 | 7,400.0 | - | - |
| Дүн | **1** | **7,400.0** | | | **1** | **7,400.0** | **1** | **7,400.0** | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ-ын дарга Б.Наранбаатарт 162.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг илүү тооцож олгосон | 1 | 162.0 | 1 | 162.0 | - | - | - | - |
| Тайлант онд урсгал засварын зардал болон хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас зарцуулсан 31,673.3 мянган төгрөгийн сэлбэгийг зарцуулсан байхад өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулаагүй. | 1 | 31,673.0 | | | 1 | 31,673.0 | - | - |
| Дүн | **2** | **31,835.0** | **1** | **162.0** | **1** | **31,673.0** | **0** | **0** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 805,910.4 мянган төгрөгийн 16 гүйлгээ мэдээлэхээс 48,135.1 мянган төгрөгийн 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 203,822.0 мянган төгрөгийн 10 гүйлгээ мэдээлэхээс 87,591.9 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна. | 1 | 135,727.0 | - | - | 1 | 135,727.0 | - | - |
| Дүн | 1 | 135,727.0 | - | - | 1 | 135,727.0 | - | - |

-----------oOo-----------

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 19 өдөр Дугаар 28/А0570240/БПА-2024/223/НА-СТА-ТШ3 Номгон

# ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тамгын газрын дарга Б.Наранбаатар нь албан томилолтоор 2023 оны 01 сарын 18-аас 4 хоног Галуут сумд ажилласан байхад нягтлан бодогч албан томилолтын нөхөн олговрыг олгохдоо аймгийн төвд ажилласнаар тооцож 162,000 (Нэг зуун жаран хоёр мянган) төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаалын 1 дэх заалт “Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг сумдад 24,000 төгрөг байрны зардлыг сумдад 40,000 төгрөг байна” гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 дахь “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050088

1. Илүү олгосон 162,000 (Нэг зуун жаран хоёр мянган) төгрөгийг нягтлан бодогчоор төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэхийг Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Наранбаатар, нягтлан бодогч Б.Анхтуяа нарт даалгав[2],[3].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АУДИТОР Н.БҮНЧИНСҮРЭН

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[4] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 19 өдөр Дугаар 50/А0570240/БПА-2024/223/НА-СТА-ТШ3 Номгон

# Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд урсгал засварын зардал болон хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас авто тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгсэл авахад 31,673,000 (Гучин нэгэн сая зургаан зуун далан гурван мянга) төгрөг зарцуулсан байхад тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т " Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

5040153

1. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийн зайлшгүй солих шаардлагатай болон, засвар үйлчилгээ хийсэн талаар дүгнэлт гаргаж нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Наранбаатар, нягтлан бодогч Б.Анхтуяа нарт даалгав[1],[2].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БҮНЧИНСҮРЭН

---

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[3] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 19 өдөр Дугаар 51/А0570240/БНА-2024/223/НА-СТА-ТШ3 Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 805,910.4 мянган төгрөгийн 16 гүйлгээ мэдээлэхээс 48,135.1 мянган төгрөгийн 5 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 203,822.0 мянган төгрөгийн 10 гүйлгээ мэдээлэхээс 87,591.9 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 109,742.6 мянган төгрөгийн 41 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа,

5040156

зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгаж нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Наранбаатар, нягтлан бодогч Б.Анхтуяа нарт даалгав[1],[2].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Н.БҮНЧИНСҮРЭН

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

[3] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно